

“ЯПОНЫ ТУХАЙ МИНИЙ ДУРСАМЖ” ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААН 2019

Зохион байгуулагч

“Японы тухай миний дурсамж” гэрэл зургийн уралдаан 2019 (цаашид “Уралдаан” гэх)-ыг Монгол улсад суугаа Японы Элчин сайдын яам (цаашид “Элчин сайдын яам” гэх), Canon Mongolia болон Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо хамтран зохион байгуулж байгаа болно.

Зорилго

Энэхүү Уралдааны зорилго нь Япон орны гадаадын зочдод толилуулах өвөрмөц гоо үзэсгэлэн, адал явдлууд тэдний нүдэнд хэрхэн тусч буйг тод томруун харуулахад оршино.

Гэрэл зургийн уралдааны тухай

Уралдаан нь Японы соёлыг олон талаас нь харуулан таниулахын зэрэгцээ Япон, Монгол хоёр улсын найрсаг харилцааг хөхиүлэн дэмжих зорилгыг агуулж буй тул оролцогчдоосоо Японы соёл, урлаг, хоол, баяр наадам, байгаль, спорт зэргийг дүрсэлсэн гэрэл зургуудыг хүлээн авахыг зорьж байна.

Хэн оролцох эрхтэй вэ?

- Уралдаанд зөвхөн Монгол улсын иргэн буюу Япон болон бусад улсын иргэншилгүй иргэд оролцоно.
- Бүртгэл эхлэх үед оролцогч нь тус Элчин сайдын яам байрлах газар нутагт оршин сууж байвал зохино.
- Уралдаанд оролцогч нь 2017 оны 6 дугаар сарын 1-нээс 2019 оны 9-р сар хүртэлх хугацаанд Япон улс руу визээр зорчсон байх ёстой бөгөөд уг хугацаанд авсан гэрэл зургаар уралдаанд оролцох боломжтой.
- **Уралдааны үр дүн гарсны дараа шалгарсан 30 оролцогчид уралдаанд илгээсэн гэрэл зургийг авсан үеийн виз, Япон улсын хилээр орч гарсан тэмдэглэгээ болон өөрийн паспортын хуулбарыг баталгаа болгон и-мэйлээр (public.diplomacy-section@ul.mofa.go.jp) илгээх ёстойг анхаарна уу.**
- Бүртгэлд хамрагдсанаар оролцогч нь албан дүрмийг хүлээн зөвшөөрч өөрийн бүртгэл нь дүрэмд заасан нөхцөл болзлуудыг бүрэн хангасныг баталгаажуулсан хэмээн үзнэ. Оролцогч бүр зөвхөн нэг (1) удаа бүртгүүлнэ.

Хэрхэн бүртгүүлэх тухай

Уралдаанд ирүүлсэн бүх зургийг тус ЭСЯ-ны зүгээс хэвлэл мэдээллийн зорилгоор буюу цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, видео, эмхэтгэл болон товхимлуудад ашиглаж болзошгүйг анхаарна уу.

Уралдаанд ирүүлэх гэрэл зургуудыг зөвхөн **Canon Mongolia** платформоор (www.canonmongolia.mn) дамжуулан **2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 9 дүгээр сарын 16-ны өдрийн** хооронд ирүүлнэ. Бусад төрлийн “file sharing” сайтуудыг ашиглах боломжгүй.

Нэг оролцогч дээд тал нь гурван (3) гэрэл зураг ирүүлэх боломжтой бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Гэрэл зургууд дижитал хэлбэртэй байх бөгөөд бүртгэлд зөвхөн онлайнаар хамрагдана. Хэвлэмэл гэрэл зураг болон хальсыг хүлээн авахгүй. Гэрэл зургийг заавал дижитал камераар авсан байх шаардлагагүй бөгөөд гар утас, дрон зэргийг ашигласан байж болно. Бүх дижитал файлууд нь 35MB буюу түүнээс бага хэмжээтэй, JPEG буюу .jpg өргөтгөлтэй, доод тал нь 1800 пиксель өргөн (хөндлөн зураг бол) буюу 1800 пиксель өндөр (босоо зураг бол)-тэй байна.
2. **Гэрэл зургууд нь Оролцогчийн 2017 оны 6 дугаар сарын 1-нээс хойших хугацаанд Япон улсад аялах үед авагдсан байна.**
3. Гэрэл зургууд нь өмнө нь аливаа уралдаанд оролцон шагнал хүртэж байгаагүй байна.
4. Зөвхөн бага зэргийн засвар (contrast, highlight, exposure г.м.) болон тайралт хийхийг зөвшөөрнө. HDR болон залгасан панорама зураг байж болно.
5. Зохиогчийн эрхийг зөрчөөгүй, хуульд нийцсэн тохиолдолд баримал, хөшөө, уран зураг болон бусад төрлийн соёл урлагийн бүтээлүүдийг харуулсан гэрэл зургийг ирүүлж болно. Бусдын бүтээлийг харуулсан гэрэл зураг нь “full-frame close-up” зураг бус, хүрээлэн буй орчныг нь багтаасан байна.
6. Гэрэл зураг нь бүхэлдээ оролцогчийн өөрийн авсан дан гац бүтээлийн эх хувь байна. Уралдаанд бүртгүүлснээрээ уг бүтээл нь оролцогчийн өөрийн авсан бүтээлийн эх хувь болохыг мэдэгдэн баталгаажуулсан, уг бүтээл нь аливаа зохиогчийн эрх, худалдааны тэмдэгт, ёс зүйн, хувь хүн буюу олон нийтийн болоод оюуны өмчийн эрхийг зөрчөөгүйг, мөн хэн нэгэн уг гэрэл зурагтай холбоо бүхий эрх эдэлдэггүй, аливаа ашиг сонирхол үгүйг нотолсон хэмээн

үзнэ.

7. Усан тэмдэг байхыг зөвшөөрөхгүй.
8. Ирүүлэх гэрэл зураг бүрийг дараах мэдээлэл дагалдана:
 - a) Оролцогчийн бүтэн нэр;
 - b) Оролцогчийн гар утасны дугаар
 - c) Оролцогчийн хувийн цахим шуудангийн хаяг, Facebook болон бусад олон нийтийн сүлжээний хаяг, линк (*байгаа тохиолдолд*);
 - d) Файлын нэр;
 - e) Гэрэл зургийн нэр;
 - f) Гэрэл зургийн агуулга (холбоо бүхий үйл явдал);
 - g) Гэрэл зургийг авсан байршил;
 - h) Авсан огноо;
 - i) Гэрэл зургийн агуулгатай холбогдох холбоос үг (#Japan #Tokyo #Landscape г.м.);

Шүүлт

Уралдаанд ирүүлсэн бүтээл (гэрэл зураг) бүрийг бусдаас тусад нь шүүнэ. Японы ЭСЯ болон хамтран зохион байгуулагчдын төлөөлөл Уралдааны шаардлагыг ханган оролцох бүтээлүүдээс сонгон 1, 2, 3 дугаар байрны эзнээр тус бүр нэг (1) хүн, мөн шилдэг 30 оролцогчийг шалгаруулна. Шалгарсан оролцогчдод цахим шуудангаар мэдэгдэх бөгөөд Японы ЭСЯ болон Canon Mongolia-гийн албаны Facebook хуудсаар дамжуулан зарлана. Шүүгчдийн шийдвэр эцсийнх байх болно.

Шүүгчдийн бүрэлдэхүүн

1. Шүүгч 1 – Мэргэжлийн гэрэл зурагчин;
2. Шүүгч 2 – Японы ЭСЯ-ны ажилтан;
3. Шүүгч 3 – Canon Mongolia-гийн ажилтан.

Үзэсгэлэн

Шилдэг 30 гэрэл зургийг хэвлүүлэн 2019 оны сүүлээр зохиогдох “Японы тухай миний дурсамж 2019” нэртэй үзэсгэлэнд дэлгэн олон нийтэд толилуулна. Үзэсгэлэнгийн талаарх мэдээллийг Японы ЭСЯ болон Canon Mongolia-гийн албан ёсны цахим хуудас, Facebook хуудсаар жич хүргэнэ.

Зөвшөөрөл

Уралдаанд оролцсоноор оролцогч нь өөрийн бүтээлийг (нэрийн хамтаар) хэвлэл мэдээллийн аль ч хэрэгсэлд хэвлэн нийтлэх, түүгээр дамжуулан түгээх, нийтэд толилуулах, дайвар бүтээл туурвих эрхийг эргэлт буцалтгүй, хугацаагүй, үнэ төлбөргүй, онцгой бус нөхцөлөөр Японы ЭСЯ-нд олгох бөгөөд үүнд Японы ЭСЯ-наас зохиох үзэсгэлэн, үзвэр, Японы ЭСЯ-наас гаргах эмхэтгэл, товхимол, сурталчилгааны хуудас болон Facebook зэрэг интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг хэрэгслүүд ч багтана.

Мэдээллийн нууцлал

Оролцогч нь өөрийн хувийн мэдээлэл, ялангуяа нэр болон хаягийг боловсруулах, хуваалцах, мөн Уралдааны хүрээнд болон энэхүү дүрэмд заасан зорилгоор ашиглахыг зөвшөөрнө. Түүнчлэн оролцогчийн нэр, шуудангийн хаяг, утасны дугаарыг тодруулах, мөн Японы ЭСЯ-наас Уралдаанд оролцох эрхийг баталгаажуулах зорилгоор уг мэдээллийг ашиглаж болно. Оролцогч нь өөрийн мэдээллийг харах, шалгах, засварлах буюу Японы ЭСЯ-ны мэдэлд буй өөрийн мэдээллийг бичгээр хүсэлт тавин устгуулах эрхтэй болно. Японы ЭСЯ болон түүнтэй холбогдох байгууллагууд нь хувийн мэдээллийг зөвхөн энд заасан зорилгоор ашиглана.

Бүртгэл дуусах хугацаа

Бүртгэлийн бүх маягт, файлуудыг **2019 оны 9 дүгээр сарын 16-ны Даваа гаригийн 17:00 цагаас өмнө** ирүүлсэн байна.

Шаардагдах бичиг баримт

- Уралдаанд оролцох цахим бүртгэл ([ЭНДЭЭС ҮЗНЭ ҮҮ](#))
- Шүүгчдийн шийдвэр гарсны дараа шалгарсан оролцогчид бүтээлээ баталгаажуулах зорилгоор паспортынхаа хуулбар (1. нүүр хуудас, 2. гэрэл зураг авах үед Япон хилээр нэвтэрсэн тэмдэглэл)-ыг public.diplomacy-section@ul.mofa.go.jp цахим хаягаар ирүүлнэ.

※ Япон улсын ЭСЯ-нь шаардлагатай тохиолдолд Уралдаан болон үзэсгэлэнг өөрчлөх, хойшлуулах буюу цуцлах эрхтэй болно.